

**“ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”
ХУУЛИЙН ТӨСӨЛД ЯАМДААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЧОО**

Батлан хамгаалахын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 1а/3259 дүгээр албан бичгийн хариу:

Д/д	Яамд	Ирүүлсэн санал
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	<p>2023.09.27-ны өдрийн 1/4958 дугаар албан бичиг: Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1-д “Тайлбар: Энэ хууль батлагдахаас өмнө Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр мөнгөн урамшуулал авсан алба хаагчид энэ хуулийн 7.1.22-т заасны дагуу мөнгөн урамшууллыг үргэжлүүлэн олгохдоо тухайн алба хаагчийн хамгийн сүүлд мөнгөн урамшуулал авсан хугацааг харгалзан 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн тооцож олгоно.” гэж тусгасан байна.</p> <p>Тус тайлбар хэсэг нь өмнө үйлчилж байсан хууль, эрх зүйн зохицуулалтын дагуу үүссэн харилцааг шинэ хуулийн дагуу хэрхэн зохицуулах тухайн нэг удаагийн шинжтэй зохион байгуулалт байх тул уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хэлбэрээр боловсруулах нь зүйтэй.</p>
2	Гадаад хэргийн яам	<p>2023.09.07-ны өдрийн 08/4725 дугаар албан бичиг: “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байна.</p>
3	Сангийн яам	<p>2023.10.10-ны өдрийн 01/7414 дүгээр албан бичиг: Танаас ирүүлсэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдтэй танилцлаа.</p> <p>Салбар бүрийн хуульд алслагдсанд тооцогдсон аймгийн төвөөс бусад сум, суурин газарт тасралтгүй тав болон түүнээс дээш ажиллаж байгаа албан хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал, улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбар, суурин бус газарт байрладаг цэргийн анги, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн анги, агааны цэргийн салбарт 25-50 хувиар тооцон олгож байгаа тул нийтлэг зохицуулалттай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна.</p> <p>Харин Зэвсэгт хүчний тухай хуульд алслагдсанд тооцогдох анги, салбарыг тодорхойлон дээрх үйл ажиллагааг зохицуулсан заалт оруулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнтэй холбоотойгоор хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.22 дахь заалтыг хасах, эсхүл салбар бүрийн хуульд тусгагдсан тэтгэмжтэй холбоотой заалтыг хасаж Цэргийн алба</p>

		<p>хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд төрийн тусгай албанд нийтлэг байдлаар хэрэгжүүлэхээр тусгах саналтай байна.</p> <p>Түүнчлэн, хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалингийн хэмжээ, нэмэгдэл олгох журмыг тусгайлан батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах шаардлагагүй нийтээр дагаж мөрдөх арга хэмжээ байх тул цалингийн хэмжээ болон батлах эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй.</p> <p>Хувийг: Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр Танаа.</p>
4	Эдийн засаг, хөгжлийн яам	<p>2023.10.03-ны өдрийн 01/1826 дугаар албан бичиг:</p> <p>Танаас 2023 оны 1а/3259 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлтэй танилцлаа.</p> <p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан “... цалингийн хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасантай нэгэн адил Засгийн газар батлахаар тусгах нь зүйтэй гэж үзэж байна.</p>
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	<p>2023.09.14-ний өдрийн 01/4928 дугаар албан бичиг:</p> <p>Танаас ирүүлсэн “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлтэй танилцлаа.</p> <p>Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй байна.</p>
6	Барилга, хот байгуулалтын яам	<p>2023.09.12-ны өдрийн 1/3322 дугаар албан бичиг:</p> <p>Таны 2023 оны 1а/3259 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл холбогдох материалтай танилцлаа.</p> <p>Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 9.5 дахь хэсгийг “9.5.Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалингийн хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлах хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж өөрчлөн найруулахаар тусгасан нь цэргийн албанд ажиллаж байгаа албан хаагчдын сурч боловсрох үйл ажиллагаанд тэгш бус ялгамжтай нөхцөл байдлыг бий болгох эрсдэлтэй тул уг заалтыг, мөн хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Цагдаагийн албаны тухай хууль нэмэлт оруулах тухай хуулийн тус тус хасах саналтай байна.</p>

7	Боловсрол, шинжлэх ухааны яам	2023.09.13-ны өдрийн 1а/4290 дүгээр албан бичиг: Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга холбогдох бусад баримт бичигтэй танилцан зарчмын хувьд дэмжиж тусгайлан өгөх саналгүй байна.
8	Зам тээврийн хөгжлийн яам	2023.09.08-ны өдрийн 02/4234 дүгээр албан бичиг: Таны 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 1а/3259 дугаар албан бичгээр ирүүлсэн “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд дараах саналыг өгч байна. Үүнд: 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 22 дахь заалт”-д нэмэлт оруулахаар тусгасан хэдий ч нэмэлт оруулах хуулийн заалтыг буруу эшилсэн байх тул төслийн 1 дэх заалтыг “7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.22 дахь заалт” гэж өөрчлөх; 2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлд “9.5.Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч суралцагчийн цалингийн хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан хэдий ч хуулийн төслийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой дагаж нэмэлт орох Цагдаагийн албаны тухай хуулийн төслийн 1-д “Дотоод, гадаадын цагдаагийн их, дээд, сургуульд суралцаж байгаа цагдаагийн алба хаагчийн цалингийн хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан нь дээрх журмыг Засгийн газрын гишүүн дангаар эсвэл хамтран батлах нь тодорхойгүй байгааг анхаарахыг хүсье.
9	Соёлын яам	2023.09.11-ний өдрийн 1/2376 дугаар албан бичиг: Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон танилцуулгатай танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй байна.
10	Хүнс хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам	2023.09.11-ны өдрийн 01/3168 дугаар албан бичиг: Таны 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 1а/3259 албан бичгээр ирүүлсэн “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөлтэй танилцаад зарчмын хувьд дэмжиж байна. Тусгайлан өгөх саналгүй болно.
11	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам	2023.09.11-ний өдрийн 01/2196 дугаар албан бичиг: Танаас ирүүлсэн “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлал холбогдох материалтай танилцлаа.

		Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна.
12	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2023.09.14-ний өдрийн 01/2277 дугаар албан бичиг: Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгатай тус тус танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.
13	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	2023.09.14-ний өдрийн 01/1841 дүгээр албан бичиг: Танаас ирүүлсэн “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл болон холбогдох материалуудтай танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.
14	Эрчим хүчний яам	2023.09.19-ний өдрийн б/3087 дугаар албан бичиг: Танаас ирүүлсэн “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох материалыг хүлээн авч танилцлаа. Хуулийн төслийн зарчмын хувьд дэмжих саналтай байна.
15	Эрүүл мэндийн яам	2023.09.11-ний өдрийн 16/4110 дугаар албан бичиг: “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Цагдаагийн албаны тухай хууль”-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох бусад баримт бичгийн төслүүдтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: 1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан санхүү, төсөв, татварын чиглэлээрх хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран батална гэж хуульчилсан. “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлангаас үзэхэд улсын төсвөөс мөнгөн урамшууллын зардалд хөрөнгө гарахаар байгаа тул хуулийн төслийн үзэл баримтлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах. 2.Дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцаж буй иргэд өөрсдөө төлбөрөө төлөх, эсхүл тэтгэлгээр суралцдаг. Гэтэл дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчдад цалин, нэмэгдэл олгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө

		<p>чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэсэнтэй зөрчилдөж байна гэж үзэж байна.</p> <p>Иймд хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу батлах, мөн хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн дахин боловсруулж, санал авахаар ирүүлнэ үү.</p>
--	--	--

---oOo---